



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/105

Арвайхээр

**Г Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай**

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 28 дүгээр зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Тус төвийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн 1 дүгээр багц хэвлийн мэс заслын дуранг 385,000,000 (гурван зуун наян таван сая) төгрөгөөр "Пролианс" ХХК-иар, 3 дугаар багц хүзүү толгой, шүдний дэлгэмэл компьютерийг 230,000,000 (хоёр зуун гучин сая) төгрөгөөр "Сүкэхолдинг" ХХК-иар, 4 дүгээр багц суурин ЭХО аппаратыг 165,000,000 (нэг зуун жаран таван сая) төгрөгөөр "Мэдикал Ресурс" ХХК-иар, 5 дугаар багц өвдөгний суурь багажийг 78,600,000 (далан найман сая зургаан зуун мянган) төгрөгөөр "Мөнгөнгөлтгөнө" ХХК-иар, 6 дугаар багц ариутгал угаалгын тоног төхөөрөмжийг 77,081,224 (далан долоон сая наян нэгэн мянга хоёр зуун хорин дөрвөн) төгрөгөөр "Ай мед техноложис" ХХК-иар тус тус гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх), гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) нарт даалгасугай.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3. дахь заалтын шаардлагад нийцээгүй 2 дугаар багц ходоодны дурангийн товер (2 бүдүүн гэдэс, 1 ходоод), 7 дугаар багц лабораторийн шинжилгээний тоног төхөөрөмжийг тус тус хүчингүй болгосугай.

4.Дээрх хүчингүй болсон багцуудыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Д.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

  
Г. ДАШЖАНЦАН  
